



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 2/27

Дэлгэрхаан сум

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлэх, төлөвлөх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 86 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлэх, төлөвлөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Засаг даргын орлогч

Гишүүд:

-Санхүүгийн дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч

-Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

-Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга

-Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

-Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн

-Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан

мэргэжилтэн

-Дэлгэрхаан-Аварга нөхөрлөлүүдийн холбоо төрийн бус

байгууллагын нарийн бичиг

Нарийн бичгийн дарга: -Сан хариуцсан нягтлан бодогч

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

ДАРГА Б.ЭНХ-АМГАЛАН



2326910950

